

Солонгос хэлний сургалт ба дуудлага

Ким Бунгүг

Бүсаны боловсролын их сургууль, эх хэлний боловсролын тэнхмийн профессор

1. Оршил

Амьд биет тасралтгүй хөдөлж, хувьсан өөрчлөгдөж байдаг. Бидний нүдэнд хөдөлгөөнгүй, өөрчлөгддөггүй мэт харагддаг зүйлс ч бодит байдал дээр тэдгээрийн дотогш нарийвчлан өнгийж үзвэл зогсолтгүй хөдөлж, өөрчлөгдөж байдаг байна. Өвлийн ид хүйтэнд бий болсон мөс хавар болоход мөс хэвээр үлдсэн мэт боловч дотроо аль хэдийнэ хаврыг угтах бэлтгэлээ хийж байдаг.

Хэл нь амьд биеттэй адил учраас тухайн байдалд өөрчлөгдөж буй нь тийм ч амархан мэдрэгдэхгүй боловч бага зэрэг нарийвчлан ажиглавал түүний өөрчлөлтийг бодитоор мэдэрч болно. Хэлэнд бичиг үсгээр тэмдэглэсэн тэмдэглэгээ нь тогтвортой байдаг учраас өөрчлөлтийг мэдрэхэд хэцүү ч түүнд нуугдсан дуу авиа ба дуудлага нь аль хэдийнэ өөрчлөгдсөн байх тохиолдлыг байнга харж болно. Жишээлбэл, '닭'-ийн тэмдэглэгээ ба үндсэн, бодит дуудлага нь [хүснэгт 1]-тэй адил ялгааг харуулж байна. '닭'-ийг <Хангыл үсгийн зөв бичихзүй>-д тохируулан тэмдэглэвэл '닭#, 닭이, 닭을, 닭에, 닭으로' болох бөгөөд үндсэн дуудлага нь [닥], [달기], [달글], [달게], [달그로] болно. Гэвч тэмдэглэгээнд нуугдсан байгаа бодит дуудлагыг бодож үзвэл [닥]#,

[Хүснэгт 1] '닭'-ийн тэмдэглэгээ ба дуудлага

Нөхцөл	___# ¹	-이	-을	-에	-으로
Тэмдэглэгээ, дуудлага					
Бодит тэмдэглэгээ	닭	닭이	닭을	닭에	닭으로
Үндсэн дуудлага	닥	달기	달글	달게	달그로
Бодит дуудлага	닥	다기	다글	다게	다그로

[다기], [다글], [다게], [다그로] болох юм. Өөрөөр хэлбэл тэмдэглэгээнд үндсэн хэлбэр нь '닭' боловч бодит дуудлагад тулгуурлавал үндсэн хэлбэрийг '닥' гэх хэрэгтэй. Илэрсэн тэмдэглэгээнд үндсэн хэлбэр нь '닭' учраас түүний өөрчлөлтийг бичгээр нягтлахад хэцүү боловч тэмдэглэгээнд нуугдсан дуудлагын бодит байдлыг харгалзан үзвэл, үндсэн хэлбэр нь '닥' болох өөрчлөлт аль хэдийнэ бий болсныг мэдэж болно. Үүнтэй адилаар илэрсэн

¹. # нь нөхцлийг залгахгүй бие даан хэрэглэгдэж буй байдлыг илэрхийлнэ.

тэмдэглэгээний бодит байдал ба нуугдсан дуудлагын бодит байдлын ялгаа нь эх хэлний сургалт, ялангуяа дуудлагыг заахад хэцүү байдал үүсэх магадлал их юм. Уг өгүүллээр эх хэлний сургалттай үргэлж тохиолдох тэмдэглэгээ ба үндсэн дуудлага, бодит дуудлагын холбоонд илрэн гарч буй асуудал ба түүнийг шийдэх аргыг дуудлагыг заахад гол анхаарал хандуулан хэлэлцэх болно.

2. «Эх хэлний тайлбар толь бичиг» ба <Үндсэн дуудахзүй>

Эх хэлний сургалтад бодит дуудлагаас илүү үндсэн дуудлагын талаарх сургалт эн тэргүүнд чухал учраас үндсэн дуудлагын тухай тодорхой мэдэх шаардлагатай. Өгүүлэгч дуудлагыг нягтлах үедээ хамгийн түрүүнд ашигладаг зүйл нь «Эх хэлний тайлбар толь бичиг» ба <Үндсэн дуудахзүй>-н дүрэм юм. Гэвч «Эх хэлний тайлбар толь бичиг»-ийн дуудлагын тэмдэглэгээ юмуу <Үндсэн дуудахзүй>-н дүрэм нь үндсэн дуудлагын талаарх мэдээллээр хангахад учир дутагдалтай тал их байдаг. «Эх хэлний тайлбар толь бичиг»-ийн дуудлагын тэмдэглэгээ нь авиазүйн нарийвчилсан хүрээг харгалзан үзээгүй байдаг учраас бодитоор хэрэгтэй агуулгыг нягтлах үед өгүүлэгчийн шаардлагыг бүрэн дүүрэн хангаж чаддаггүй төдийгүй <Үндсэн дуудахзүй>-н дүрэм нь багш нар болон энгийн ард иргэдэд амархан ойлгогдохгүй байх талтай.

Хэлний хэрэглэгчдийн дуудлагын тэмдэглэгээг мэдэхийг хүсэх үед хамгийн түрүүнд санаанд ордог зүйл нь «Эх хэлний тайлбар толь бичиг» юм. Гэхдээ «Эх хэлний тайлбар толь бичиг»-ийн дуудлагын тэмдэглэгээ нь хэрэглэгчийн шаардлагыг хангаж буй эсэхийг дахин бодож үзэх хэрэгтэй. Толь бичгийн дуудлагын тэмдэглэгээтэй холбогдуулан эхлээд толь бичгийн толгой үг болох ‘**प्따**’-г хайж үзвэл дараах мэдээллийг нягталж болно.

प्따 01 [막따]

Хувилал: **प्따**, **प्따**니, **प्따**고[말꼬], **प्따**지[막지]

Нэрийн нөхцөл ба үйлийн нөхцөл их хөгжсөн нь эх хэлний нэг онцлог гэж хэлж болно. Үүнийг бодож үзвэл хувилал ба дуудлага маш товч тэмдэглэгдсэн байдаг. Тухайлбал ‘**प्따**, **प्따**고, **प्따**지’-ийн талаар хувилал ба дуудлага л тэмдэглэгдсэн байдаг болохоор ‘**प्따**니, **प्따**소’-тай адил гийгүүлэгчээр төгссөн үйлийн нөхцөл залгасан хувилал ба дуудлагыг мэдэхэд хэцүү. Ийм учраас «Эх хэлний тайлбар толь бичиг»-ийн дутагдалтай дуудлагын тэмдэглэгээг нөхөж болох <Үндсэн дуудлагын толь бичиг>-ийн шаардлага бий болж байна. <Үндсэн дуудахзүй> нь ерөнхий тогтолцоо ба зарчмыг голлож, нарийвчилсан дуудлагын тэмдэглэгээг <Үндсэн дуудлагын толь бичиг>-т зааж өгвөл хэлний хэрэглэгчдийн дуудлагыг мэдэх хүслийг тодорхой хэмжээнд хангаж өгөх болов уу гэж бодож байна.

Түүнчлэн үндсэн дуудлагыг заахад зориулж юуны өмнө <Үндсэн дуудахзүй>-н дүрмийн тогтолцоог шинээр засч, хэрэггүй хэсгийг цэгцлэх шаардлагатай байна. Сургуулийн багш нар <Үндсэн дуудахзүй>-н дүрмийн талаар мэдэх нь мэдэж байдаг.² Гэхдээ дүрэм нь жишээгээр тайлбарласан байдаг болохоор системтэй биш учраас суралцагчид ойлгоход хүндрэлтэй байж болно. Үүнтэй адилаар дүрэмд байх үндсэн дуудлагын жишээ нь

² Зарим бага сургуулийн багш нар энэ дүрэм байдгийг мэдэхгүй юмуу мэдэж байсан ч хаана байдгийг мэдэхгүй тохиолдол байдаг.

системтэй биш бөгөөд сургалтад тулгарах хэд хэдэн бэрхшээл байдаг байна. Давхар дэвсгэр үсгийн дуудлага, “нэр үг+дуудахын тийн ялгал”-ын дуудлага, авианы урт, дан эгшиг ‘ㄱ, ㅋ’ –ийн дуудлага зэрэг нь үүнд хамаарна.

3. Давхар дэвсгэр үсгийн дуудлага

Давхар дэвсгэр үсэгтэй холбоотой үндсэн дуудлага нь ялангуяа маргаан үүсгэдэг. Давхар дэвсгэр үсгийн дуудлага нь нутгийн аялгуу бүрт ялгаатай байдаг учраас үндсэн дуудлага нь бодит дуудлагаас их ялгаатай байдаг байна.

11-р зүйл Давхар дэвсгэр үсэг ‘ㄹ, ㄺ, ㄻ’ нь үгийн төгсгөлд ба гийгүүлэгчийн өмнө [ㄱ, ㅋ, ㅌ] болж тус тус дуудагдана.

답[다] ㄹ과[ㄹ꽈] ㅌ다[ㅌ따] ㄹ지[ㄹ찌] ㅌ[삼:]
 ㅌ다[ㅌ점:] ㅌ고[ㅌ꼬] ㅌ다[ㅌ따]

Зөвхөн, хувирдаг үгийн язгуурын төгсгөл ‘ㄹ’ нь ‘ㄱ’-ийн өмнө [ㅋ] болж дуудагдана.

ㅌ게[말게] ㅌ고[물꼬] ㅌ거나[얼이거나]

Энэ дүрэмд ‘ㄹ’ –ийг л ажиглаж үзвэл хувирдаг үгийн төгсгөлийн авиа ‘ㄹ’ байх үед үйлийн нөхцлийн эхний авиа ‘ㄱ’-ийн өмнө ‘ㄱ’ нь гээгдэж, бусад тохиолдолд ‘ㄹ’-ийн ‘ㄹ’ нь гээгдэнэ. Энэ дүрмийг [Хүснэгт 2] –т үзүүлье.

[Хүснэгт 2] Давхар дэвсгэр үсэг ‘ㄹ’-ийн дуудлага

Хүрээ Үг	Нэршсэн үг					Хувирдаг үг				
	답					ㅌ-				
Тэмдэглэгээ	답#	답과	답도	답만	답조차	ㅌ고	ㅌ다	ㅌ지	ㅌ니	ㅌ소
Үндсэн дуудлага	다	다과	다또	다만	다조차	말꼬	막따	막찌	망니	막쏘
Гээгдэх гийгүүлэгч	ㄹ	ㄹ	ㄹ	ㄹ	ㄹ	ㄱ	ㅋ	ㅋ	ㅋ	ㅋ

Гэхдээ [Хүснэгт 2]-т зааснаас өөрөөр бодит дуудлагад гарсан ‘ㄹ’-ийн гээгдэх үзэгдэл нь бүс нутгаас шалтгаалан өөрөөр илрэх тохиолдол нэлээн их байдаг. Хувирдаг үгийн язгуурын сүүлийн авиа давхар дэвсгэр үсэг байвал хойноос нь залгагдах үйлийн нөхцлийн эхний авианаас хамаарч гээгдэж буй гийгүүлэгч нь өөр байх дүрмийг суралцагчдад тайлбарлахад хэцүү байдаг. Эх хэлэнд язгуурын сүүлийн авиа давхар дэвсгэр үсэг байх үед хойноос нь гийгүүлэгч орвол нэг гийгүүлэгч нь гээгддэг дүрэм (Гийгүүлэгчид хураагдах дүрэм) байх боловч яагаад ‘ㅌ고’-ийн тохиолдолд л гээгдэж буй гийгүүлэгч нь ‘ㄱ’ болохыг суралцагчдад ойлгуулахад хялбар биш юм. Мэдээж бодит дуудлага нь тийм учраас юм гэж ядсан тайлбар хийж болох ч [Хүснэгт 2]-т заасан үндсэн дуудлага нь бүгд бодит дуудлага гэж өгүүлэгч ойлгох эсэх нь асуудал юм. Мөн үүнийг заах байр суурьнаас үндсэн

дуудлага нь бодит дуудлагаас өөр учраас энгийн цээжлүүлэх аргаас өөр үр дүнтэй заах арга гэж байхгүй юм. Энэ нь ч давхар дэвсгэр үсэгтэй холбоотой үндсэн дуудлагын асуудал гэж хэлж болно.

Үндсэн дуудлага бодит дуудлагаас өөр байгаа байдал ба сургалтын үүднээс үзвэл давхар дэвсгэр үсэг дундаас гээгдэж буй гийгүүлэгчийг аль нэг тал руу нь нэгтгэх арга, эсвэл аль ч тал нь гээгдсэн хамаагүй хоёуланг нь хүлээн зөвшөөрдөг төв аялгуутай адил хоёр дуудлагыг үндсэн дуудлагаар хүлээн зөвшөөрөх арга бий. Давхар дэвсгэр үсэг дундаас гээгдэж буй гийгүүлэгчийг аль нэг тал руу нь нэгтгэх арга юмуу аль ч гийгүүлэгч гээгдсэн хоёуланг зөвшөөрөх арга нь хэлний бодит амьдралд утгыг илэрхийлэхэд саад болох хэмжээний биш бөгөөд харилцан ярианд ч том хүндрэл учруулахгүй гэж бодож байна. Сургалтын үүднээс суралцагчдад давхар дэвсгэр үсэг дунд гээгдэх гийгүүлэгчийг аль нэг тал руу нь нэгтгэх аргыг заах нь хялбар байж мэдэх ч нутгийн аялгуунаас хамаарч гээгддэг гийгүүлэгч нь өөр учраас суралцагчид аль ч хэлбэрээр бай бодит дуудлагаас хол ялгаатайг мэдэрч болно. Тэгвэл бодит дуудлагаас ялгаатай байгааг багасгах боломжтой арга нь хос үндсэн дуудлагыг хүлээн зөвшөөрөх явдал юм.

4. 'Нэр үг + Дуудахын тийн ялгалын нөхцөл'-ийн дуудлага

Үндсэн дуудлагатай холбоотойгоор бодит дуудлагаас их ялгаатай учраас дуудлагыг заахад хэцүү болгодог жишээнд 'Нэр үг + дуудахын тийн ялгалын нөхцөл'-ийн нэгдлийг дурдаж болно. Сүүлийн үед уугуул үгээс бүтсэн нэрийг³ байнга харж болох бөгөөд '폴잎, 한빛' зэрэг бол түүний жишээ юм. Бодит сургалтад 'Нэр үг + дуудахын тийн ялгалын нөхцөл'-ийн дуудлагыг заахдаа үгийн язгуурын сүүлийн авиа нь эгшгээр эхэлсэн нөхцөл орвол хойд үе рүү шилжиж дуудагддаг үзэгдлийн улмаас '폴잎, 한빛' гэх нэр нь үндсэн дуудлагаар '폴잎아[폴리파]' бас '한빛아[한비차]' гэж заах ёстой. Гэхдээ үүнтэй адилаар дуудвал суралцагчид толгой сэгсрэн гайхах тохиолдолтой үе үе тулгарах нь бий. Суралцагчид эсрэгээрээ '폴잎아[폴리마]' юмуу '한빛아[한비다]' гэж дуудах нь илүү энгийн гэх хандлагыг харуулах бөгөөд иймэрхүү суралцагчийн хандлага нь үндсэн ба бодит дуудлагын ялгааг тэр чигээр нь харуулж өгсөн сайхан жишээ гэж хэлж болно.

Үүнийг энгийнээр тайлбарлавал чанга авиа болох 'ㄷ, ㅌ, ㅍ, ㅊ' зэрэг нь үгийн язгуурын сүүлийн авиа болж дуудахын тийн ялгалтай нийлэх үед үндсэн ба бодит дуудлагын ялгаа гарч байна гэж хэлж болно. Гэхдээ хүний нэрээс гадна дуудахын нөхцөлтэй нэр үг нийлсэн жишээ ихгүй бөгөөд ялангуяа хүний нэрийн сүүлийн авиа чанга авиагаар төгсөх тохиолдол нэг их байхгүй учраас иймэрхүү ялгаа нь дасаагүй дуудлагаас бий болсон зүйл гэж бодож болно.

Уран зохиолын бүтээлд эд юмсыг хүнчилж дуудах үед 'Нэр үг + дуудахын тийн ялгалын нөхцөл'-ийн дуудлага гарч ирэх нь бий. '폴밭, 폴꽃' зэргийг хүнчилж дуудах үед багш үүнийг үндсэн дуудлага болох '폴밭아[폴바타], 폴꽃아[폴꼬차]' гэж дуудвал, магадгүй олон суралцагчид инээх юмуу эвгүй юм гэж бодох болно. Мэдээж энэ эвгүй байдал нь бодит

³. '김폴잎' юмуу '이 한빛'-тай адил хүний нэрийг 'Хангыл нэр' гэнэ. 'Хангыл нэр' нь Хангыл үсгээр бичигдсэн нэрийг хэлэх бөгөөд '폴잎, 한빛, 로버트' бүгд хангыл үсгээр бичигдсэн ба хангыл нэр гэж нэрлэх хэрэгтэй. Харин өгүүлэгч нь хангыл нэр гэж хэлэх үед '폴잎, 한빛' зэрэг л санаанд орох бөгөөд '로버트' -ийг санадаггүй. Энэ нь өгүүлэгчийн мэддэг 'хангыл нэр' нь эцэстээ 'уугуул үгээс бүтсэн нэр' -ийг илтгэх учраас 'Хангыл нэр' гэсэн буруу илэрхийллээс 'Уугуул нэр' гэсэн зөв илэрхийллийг хэрэглэх хэрэгцээ бий болж байна.

дуудлагад бараг хэрэглэхгүй уран зохиолын бүтээлд л гардаг учраас байж болох ч иймэрхүү үндсэн дуудлага зохиол бүтээлд уг үгийн агуулж байдаг уугуул өнгө аяс, мэдрэмжийг байх ёстойгоор нь харуулахад хэцүү учраас ч гэж хэлж болно.

‘Нэр үг + дуудахын тийн ялгалын нөхцөл’-ийн дуудлага нь үүний өмнөх үндсэн дуудлагын дүрэмд ч том асуудал болохгүй боловч бодит хэлэнд түүний хэрэглээ тодорхой хэмжээнд илэрдэг учраас аль ч хэлбэрээр бай үндсэн дуудлагыг тогтоох хэрэгцээ байгаа юм. Мөн үндсэн ба бодит дуудлагын ялгаа эрс тэс учраас бодит дуудлагад үндэслэж, хоёр дуудлагыг үндсэн дуудлагаар зөвшөөрөх нь ч бас сайн арга юм. Давхар дэвсгэр үсгийн урд талын гийгүүлэгчийн гээгдэл нь харилцан ярианд том саад учруулахгүй боловч ‘Нэр үг + дуудахын тийн ялгалын нөхцөл’-ийн дуудлага нь харилцан яриаг илүү эвгүй болгох ба ялангуяа зохиол бүтээлд ‘Нэр үг + дуудахын тийн ялгалын нөхцөл’-ийг дуудах үед үгийн агуулж буй өнгө аяс ба мэдрэмж, хам сэдвийн утгыг бүрмөсөн өөрчлөх нь ч бий. Тийм учраас хоёр дуудлагыг үндсэн дуудлагаар зөвшөөрөх хандлага шаардлагатай байна.

5. Авианы урт

Эх хэлний дуудлагыг заахад хэцүү зүйлүүдийн нэг нь урт богино авианы асуудал юм. Орчин цагийн солонгос хэлний нутгийн аялгууг үзвэл авианы уртаар утга нь ялгагддаг бүс нутаг ба авианы өндөр намаар утга нь ялгагддаг бүс нутаг гэж хувааж болно. Энэ дундаас <Үндсэн дуудахзүй>-д авианы уртыг л хүлээн зөвшөөрч, авианы өндөр намыг хүлээн зөвшөөрөөгүй. Мөн бодит дуудлагад авианы уртаар үгийн утгыг ялгаж чадахгүй байх тохиолдол их бий.

Ийм тал нь бодит сургалтад ч яг адил юм. Гёнсан аймаг юмуу Ганвөн аймгийн Ёндуны бүс нутагт ч авианы өндөр нам нь үгийн утгыг ялгахад чухал үүрэгтэй учраас авианы уртыг заах нь нутгийн аялгууны онцлог ба бодит дуудлагыг харгалзаж үзэлгүй бараг утгагүй зүйл мэт мэдрэгдэнэ. Ийм бүс нутгийн суралцагчдад авианы уртын талаар заах нь угаас боломжгүй зүйл бөгөөд заасан ч суралцагчид энгийн цээжлүүлэх аргаас гадна өөр арга байхгүй. Цээжлүүлсэн ч суралцагчид удахгүй мартдаг учраас дуудлагыг заахад ач холбогдол өгөхөд хэцүү.

Энэ нь авианы уртыг заахад ч ялгаагүй юм. <Үндсэн дуудахзүй>-н дүрмээс өөрөөр бодит дуудлагад авианы уртыг хүлээн зөвшөөрөхөд амар биш. Авианы уртыг хүлээн зөвшөөрөх гэдэг нь эх хэлний түүхийн нэг хэсгийг хүлээн зөвшөөрч байна гэсэн үг юм. Гэвч бодитоор авианы уртаар үгийн утгыг ялгадаг өгүүлэгч олон биш бөгөөд ихэнх нь урт богино нь бага зэргийн буруу байсан ч хам сэдвээр нь түүний утгыг ойлгож болох учраас авианы уртын чухал байдал нь тийм ч их биш юм. Мөн сургалтын үүднээс ч авианы уртын талаар заах нь энгийн цээжлүүлэх аргыг чухалчилсан заах аргаас өөр арга байхгүй учраас ийн заах нь утгагүй.

Үүнийг харгалзаж үзвэл <Үндсэн дуудахзүй>-д авианы уртын дүрэм нь эх хэлний түүхийн нэг хэсэг учраас хичээлд тайлбарлахаас гадна бодит дуудлагыг хэлж өгөх бөгөөд нарийн тод агуулга нь <Үндсэн дуудлагын толь бичиг>-ийг ашиглахад болно. Мөн сургалтад дүрмийг эн тэргүүнд тавьж зөв буруу эсэхэд анхаарал хандуулахаас илүүтэйгээр авианы урт нь эх хэлний түүхийн нэг хэсэг бөгөөд эх хэлний онцлогийн нэг болохыг тодотгон гаргахад анхаарал хандуулах хэрэгтэй байна.

6. Дан эгшиг ‘ㅓ, ㅗ’ –ийн дуудлага

<Үндсэн дуудахзүй> 4-р зүйлд дан эгшиг ‘ㅓ, ㅗ’-ийн дуудлагын талаарх дүрэм байдаг.

**4-р зүйл ‘ㅏ ㅓ ㅗ ㅛ ㅜ ㅠ ㅡ ㅝ’ нь дан эгшиг(單母音)-ээр дуудагдана.
[Нэмэлт] ‘ㅓ, ㅗ’ нь хос эгшгээр дуудаж болно.**

Уг дүрмийг баримталбал үндсэн дуудлагын хувьд ‘ㅓ, ㅗ’-ийг дан эгшгээр ч дуудаж болно, хос эгшгээр ч дуудаж болно. Тийм учраас сургалтад ‘ㅓ, ㅗ’ нь дан эгшгээр ч дуудагдаж, хос эгшгээр ч дуудагдана гэж заадаг. Гэхдээ хэлний бодит байдалд зарим нутгийн аялгууны ахмад насны өгүүлэгчдийн дунд л ‘ㅓ, ㅗ’-ийг дан эгшгээр дуудаж, үүнээс гадна ихэнх нь хос эгшгээр дууддаг.

Ийм хэлний бодит байдлаар ‘ㅓ, ㅗ’-ийн дуудлагыг сурч байгаа суралцагч төдийгүй дуудлагыг зааж буй багш нар хүртэл ‘ㅓ, ㅗ’-г дан эгшгээр дуудаж буйг сонссон удаагүй байх юмуу дуудаж үзсэн удаа байхгүй болохоор ‘ㅓ, ㅗ’-г дан эгшгээр дуудах нь хэцүү байдаг. Үүнээс шалтгаалаад үндсэн дуудлагад ‘ㅓ, ㅗ’-г дан эгшиг юмуу хос эгшгээр дуудахыг хоёуланг нь хүлээн зөвшөөрөх нь бодит шийдэх арга гэж хэлэхэд хэцүү учраас зөвхөн хос эгшгээр дуудахыг хүлээн зөвшөөрөхөд болох мэт санагдана. Дахин нэг зүйл нэмж хэлэхэд ‘ㅓ, ㅗ’-ийн нарийвчилсан дуудлага ба үндсэн дуудлагыг тодорхой заах хэрэгцээ байна.

‘ㅗ’-ийн хувьд гэвэл, Сөүл аялгуунд ‘ㅗ’ нь дан эгшиг [ü]-ээр дуудагдах нь ч бий боловч хос эгшиг [wi] ба [çi]-ээр дуудагдах нь ч бий. И Хыйсын(1955) нь дан эгшиг [ü] ба хос эгшиг [çi]-ийг хоёуланг нь хүлээн зөвшөөрч эдгээрийг авиазүйгээр нарийвчилсан тархалтыг харуулсныг дурдаж болно. Нөгөө талаар И Хёнбуг(1985) нь ‘ㄱ, ㄷ, ㄱ, ㅅ, ㅈ, ㅊ, ㅌ’-тай адил гийгүүлэгчийн ард орох ‘ㅗ’ нь [çi]-ээр дуудагдаж, ‘위, 위장’-тай адил эхний үеийн эхний авиа байхгүй тохиолдолд ‘ㅗ’ нь [wi]-ээр дуудагдаж, ‘들쭉, 날뛰다, 따귀’-д ховор [ü]-ээр бодитоор дуудагдана гэсэн байна. Ижил Сөүлийн аялгуунд ч ‘ㅗ’ нь авиазүйгээс хамаарч дан эгшгээс гадна хос эгшиг [çi] бас [wi]-ээр дуудагдаж болно гэсэн дүгнэлтэд хүрч байна. Бие даасан нутгийн аялгуу болох Чүнчөнг нутгийн аялгуунд ‘ㅗ’ нь уруудах хос эгшиг [uy]-ээр дуудагдах нь ч бий бөгөөд эдгээрийг бодож үзвэл ‘ㅗ’ нь эх хэлэнд ‘[ü], [wi], [çi], [uy]’ гэсэн 4 дуудлагатай байна.

Ингэж олон янзын дуудлагатай ч <Үндсэн дуудахзүй>-д ‘ㅗ’ нь дан эгшиг ба хос эгшгээр дуудагдаж болно гэсэн дүрэм л байдаг. Тиймээс ‘ㅗ’-ийн үндсэн дуудлагыг тогтоохдоо дараах аргуудыг ашиглаж болно. Нэгдүгээрт, <Үндсэн дуудахзүй>-д авианы хэлбэрийг тодорхой заах, хоёрдугаарт <Үндсэн дуудахзүй>-д ‘ㅗ’ нь хос эгшгээр дуудагдана гэж зааж өгөөд <Үндсэн дуудлагын толь бичиг>-т ‘ㅗ’-ийн авианы хэлбэр дундаас [wi], [çi],[uy] зэрэг нь ямар нөхцөлд хэрхэн дуудагдахыг тодорхой зааж өгч болно.

7. Дүгнэлт

Эх хэлний сургалтад дуудлагын сургалтын эзлэх байр суурь хэр зэрэг болохыг шийдэхэд амар биш боловч, багадаа л дуудлагыг заах нь эх хэлний боловсролын тулгуур хэсэг болох нь үнэн юм. Тиймдээ ч дуудлагыг заах нь байнга асуудлыг үүсгэж байдаг. Түүний шалтгаан нь тэмдэглэгээ ба үндсэн дуудлага, мөн түүний бодит дуудлага нь ялгаатай учраас юм. Дүрэм байсан ч тэр дүрэм нь тусгалаа олсон үндсэн дуудлага нь бодит дуудлагатай холбоогүй байвал тэр дүрмийг баримтлахгүй байх төдийгүй дүрэм нь бодит дуудлагыг эсрэгээрээ хязгаарлаж, ээдрээтэй болгож болох юм.

Хамгийн сайн загвар бол үндсэн ба бодит дуудлага нь ижил байх ёстой боловч үнэндээ тийм биш болохоор энэ хоёрын холбоо хол байгаа юм.

Өмнө дурдсан давхар дэвсгэр үсгийн дуудлага, Нэр үг + дуудахын тийн ялгалын нөхцөл, авианы урт, дан эгшиг 'л', 'л'-ийн дуудлагын асуудал нь үндсэн ба бодит дуудлага нь хоорондоо хол ялгаатай байгааг харуулж байгаа жишээнүүд юм. Үүнийг давж гарахын тулд эхлээд <Үндсэн дуудахзүй>-н тогтолцоог дахин сайжруулж, үүнийг нөхөж өгөх <Үндсэн дуудлагын толь бичиг>-ийг хэвлэж гаргах хэрэгтэй байна. Үүний зэрэгцээ үндсэн ба бодит дуудлагын ялгааг багасгахын тулд хоёр дуудлагыг үндсэн дуудлагаар хүлээн зөвшөөрөх аргыг ч бас одоо цагт бодож үзэх хэрэгтэй байна.

Номзүй

김봉국(2008), 음운론적관점에서본[표준어규정(제 2 부표준발음법)]의문제점, 《열린정신인문학연구》9 권 1 호, 원광대학교인문학연구소.

김성규(2012), 《표준발음법영향평가》, 국립국어원.

이승왕(2007), 체언어간말격음트,츠의실현양상과지도방안, 부산교육대학교 석사학위논문.

이현복(1985), 모음/위/의소리값, 《말소리》9 권 10 호, 대한음성학회.

이희승(1955), 《국어학개설》, 민중서관.

Сэтгүүлийн нэр: Сэгүгөсөнхуал

Хэвлэгдсэн газар: БНСУ-ын эх хэлний академи

Сэтгүүлийн дугаар: 2015 оны 25-р боть, №1 Хавар

Хуудас: 17-28

Орчуулсан: Ч.Дүүрэнжаргал

2016.01:20